БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/35/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: К.Еркегүл<br>Утас: 98420220 Цахим хаяг: Erkegulk@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....3
Асуудлыг онцолсон хэсэг .....Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал .....Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....16
4.1 Ерөнхий зүйл .....16
4.2 Материаллаг байдал .....17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....18
4.5.1 Завсрын аудитын талаар .....18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт .....18
5.2 Албан шаардлага .....18
5.3 Зөвлөмж .....18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 203
танай ______ -ны № ______ -т

БАЯННУУР СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.АЛТАНГҮЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Хүнсний материалын тооллого, тооцоог зохих журмаар хийгээгүй, үлдэгдэл тооллогоор 5,731.0 мянган төгрөг боловч санхүүгийн тайланд 10,247.0 мянган төгрөгөөр тайлагнаж, олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3452.6 мянган төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагыг санхүүгийн тайланд тусгасан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн** 5.1 дэх хэсгийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, УСНББОУС 1 стандарттай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Бараа материалын тайлан гаргалт, тооцоо бодолт, тооллого, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй хөтлөгдсөн.

**Аудитын гол асуудал**

Хүнсний материалын тайлан, тооцоо, зарцуулалт, тооллогод тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33890865.99** | **34691414.60** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 0.20 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 0.20 |
| 31110 | Төгрөг | 0.00 | 0.20 |
| **33** | **АВЛАГА** | 3861042.00 | 3861042.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 408438.00 | 408438.00 |
| **335** | **Бусад авлага** | 3452604.00 | 3452604.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3452604.00 | 3452604.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 30029823.99 | 30830372.40 |
| **354** | **Хангамжийн материал** | 30029823.99 | 30830372.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 35000.00 | 35000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8699494.00 | 11750994.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 632.00 | 361503.00 |
| 35460 | Хүнсний материал | 12858861.99 | 10247039.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8435836.00 | 8435836.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **245987447.07** | **265228636.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 245987447.07 | 265228636.59 |
| **392** | **Биет хөрөнгө** | 233477447.07 | 252718636.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 241049883.28 | 257049883.28 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -15429994.08 | -19287492.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 24629408.00 | 28803008.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20174048.70 | -20291538.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51335428.00 | 55514428.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -51114241.43 | -52169415.87 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16625741.34 | 16625741.34 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -16344509.34 | -16425756.84 |
| 39217 | Ном | 2899780.00 | 2899780.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12510000.00 | 12510000.00 |
| 39301 | Програм хангамж | 550000.00 | 550000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550000.00 | -550000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12510000.00 | 12510000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **279878313.06** | **299920051.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1209083.20** | **2714949.62** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1209083.20 | 2714949.62 |
| **413** | **Өглөг** | 1209083.20 | 2714949.62 |

| | | | |
|---|---|---|---|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 128059.62 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 24500.00 | 24500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1184583.20 | 2562390.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 87500.00 | 2258390.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1097083.20 | 304000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **278669229.86** | **297205101.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 278669229.86 | 297205101.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 73650520.00 | 73650520.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 73650520.00 | 73650520.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -39992220.88 | -21456349.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -39992220.88 | -39992220.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 18535871.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 245010930.74 | 245010930.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **279878313.06** | **299920051.19** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **448,824,600.00** | **532,367,448.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **30,993,448.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 30,993,448.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 30,993,448.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,993,448.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 21,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **448,824,600.00** | **501,374,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 421,886,700.00 | 437,420,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 421,886,700.00 | 437,420,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,937,900.00 | 63,850,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,937,900.00 | 63,850,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **456,207,537.39** | **513,831,576.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **456,207,537.39** | **513,831,576.29** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 455,594,308.39 | 513,391,311.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 346,496,732.00 | 361,773,755.89 |
| 210101 | Үндсэн цалин | 311,089,832.00 | 361,773,755.89 |
| 210104 | Урамшуулал | 22,966,300.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,440,600.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,227,297.00 | 45,144,448.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,227,297.00 | 45,144,448.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,738,500.00 | 28,459,517.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,131,900.00 | 998,517.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,606,600.00 | 27,461,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,965,200.00 | 339,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 387,800.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 666,000.00 | 339,150.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 457,000.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 44,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 410,400.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 22,103,855.66 | 65,185,829.39 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 173,000.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 21,454,855.66 | 65,185,829.39 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 476,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 350,000.00 | 218,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 350,000.00 | 218,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 344,400.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 344,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 396,500.00 | 1,110,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 146,500.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,971,823.73 | 11,159,710.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,101,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,158,456.00 | 2,947,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,813,367.73 | 5,111,410.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 613,229.00 | 440,265.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 613,229.00 | 440,265.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 613,229.00 | 440,265.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213304 | Хөрөнгийн | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(7,382,937.39)** | **18,535,871.71** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(7,382,937.39)** | **18,535,871.71** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **448824600.00** | **511367448.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0.00** | **9993448.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | 9993448.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.00 | 9993448.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 9993448.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **448824600.00** | **501374000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 421886700.00 | 437420100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 421886700.00 | 437420100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 103500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 103500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26937900.00 | 63850400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26937900.00 | 63850400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **447646100.00** | **506796847.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **447646100.00** | **506796847.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **447032871.00** | **506356582.80** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 339938848.00 | 361897044.80 |
| 210101 | Үндсэн цалин | 303672847.00 | 297772967.60 |
| 210102 | Нэмэгдэл | | 55878739.20 |
| 210104 | Урамшуулал | 22966300.00 | 8245338.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13299701.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43369200.00 | 44893100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30519000.00 | 30527100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3212500.00 | 3591500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2570100.00 | 2873200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 642500.00 | 718400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6425100.00 | 7182900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26507000.00 | 29227517.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1131900.00 | 1406517.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25375100.00 | 27821000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2537044.00 | 443521.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 390400.00 | 103500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 666000.00 | 340021.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 457000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1023644.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 33319723.00 | 59533500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 78100.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 32606923.00 | 59533500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 634700.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 210000.00 | 218900.00 |
| 210604 | Урсгал засвар | 210000.00 | 218900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 344400.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 344400.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 396500.00 | 1110000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 146500.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1110000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 410156.00 | 9033000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5733000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 410156.00 | 3300000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **613229.00** | **440265.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 613229.00 | 440265.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 613229.00 | 440265.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1178500.00** | **4570600.20** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1178500.00** | **4570600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1178500.00** | **4570600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1178500.00 | 4570600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1178500.00 | 4570600.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.00 | 0.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1178500.00** | **-4570600.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.20 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 0.20 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 73,650,520.00 | 245,010,930.74 | -39,992,220.88 | 0.00 | 278,669,229.86 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 73,650,520.00 | 245,010,930.74 | -39,992,220.88 | 0.00 | 278,669,229.86 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 73,650,520.00 | 245,010,930.74 | -39,992,220.88 | 0.00 | 278,669,229.86 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 18,535,871.71 | | 18,535,871.71 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 73,650,520.00 | 245,010,930.74 | -21,456,349.17 | 0.00 | 297,205,101.57 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **393,760,100.00** | **393,742,309.03** | **501,270,500.00** | **500,830,234.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **393,760,100.00** | **393,742,309.03** | **501,270,500.00** | **500,830,234.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 393,760,100.00 | 393,742,309.03 | 501,270,500.00 | 500,830,234.80 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 262,299,400.00 | 262,281,609.03 | 354,918,500.00 | 354,918,429.80 |
| 210101 | Үндсэн цалин | 234,065,300.00 | 234,065,300.00 | 290,547,700.00 | 292,365,315.60 |
| 210102 | Нэмэгдэл | | | 57,176,700.00 | 55,878,739.20 |
| 210104 | Урамшуулал | 24,929,000.00 | 24,929,000.00 | 7,194,100.00 | 6,674,375.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,305,100.00 | 3,287,309.03 | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,787,400.00 | 32,787,400.00 | 44,893,100.00 | 44,893,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,295,500.00 | 22,295,500.00 | 30,527,100.00 | 30,527,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,408,100.00 | 2,408,100.00 | 3,591,500.00 | 3,591,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,313,300.00 | 2,313,300.00 | 2,873,200.00 | 2,873,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 524,600.00 | 524,600.00 | 718,400.00 | 718,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,245,900.00 | 5,245,900.00 | 7,182,900.00 | 7,182,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,679,100.00 | 31,679,100.00 | 29,112,879.00 | 28,672,684.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 894,900.00 | 894,900.00 | 1,631,900.00 | 1,191,705.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,784,200.00 | 30,784,200.00 | 27,480,979.00 | 27,480,979.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,472,000.00 | 3,472,000.00 | 340,021.00 | 340,021.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 390,600.00 | 390,600.00 | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,332,000.00 | 1,332,000.00 | 340,021.00 | 340,021.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 270,000.00 | 270,000.00 | | |
| 210404 | Ном, хэвлэл | 87,900.00 | 87,900.00 | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,391,500.00 | 1,391,500.00 | | |
| **2105** | **Нормативт зардал** | 61,255,300.00 | 61,255,300.00 | 57,073,500.00 | 57,073,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 78,100.00 | 78,100.00 | | |
| 210502 | Хоол, хүнс | 60,542,500.00 | 60,542,500.00 | 57,073,500.00 | 57,073,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 634,700.00 | 634,700.00 | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 0.00 | 218,900.00 | 218,900.00 |
| 210604 | Урсгал засвар | | | 218,900.00 | 218,900.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 390,600.00 | 390,600.00 | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 390,600.00 | 390,600.00 | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200,000.00 | 200,000.00 | 1,110,000.00 | 1,110,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | | 1,110,000.00 | 1,110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,676,300.00 | 1,676,300.00 | 13,603,600.00 | 13,603,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 10,303,600.00 | 10,303,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,676,300.00 | 1,676,300.00 | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **0.00** | **501,270,500.00** | **500,830,235.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 | 437,420,100.00 | 437,420,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | 437,420,100.00 | 437,420,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.00 | 0.00 | 63,850,400.00 | 63,410,135.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | | | 63,850,400.00 | 63,410,135.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | 0.20 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 0.00 | 0.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | | | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0.00 | 0.00 | 32.00 | 32.00 |
| 620001 | Удирдах ажилтан | | | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | | 19.00 | 19.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | 12.00 | 12.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 0.00 | 0.00 | 1.00 | 1.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ** | 0.00 | 0.00 | 1.00 | 1.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | | | | |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | | | 1.00 | 1.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **103500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **103500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 103500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 103500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 103500.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **103500.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 103500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 9993448.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 9993448.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 9,993,448.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлсэн байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Цэцэрлэг нь хамрах хүрээний тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн тусалцаа үзүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Баяннуур сумын Хүүхдийн хүүхдийн цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр буюу 1.07 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0.2 | 0.2 |
| Авлага | 3,861.00 | 3,861.00 | 0.00 |
| Бараа материал | 30,029.80 | 30,830.30 | 800.5 |
| Үндсэн хөрөнгө | 245,987.40 | 265,228.60 | 19241.2 |
| **Нийт хөрөнгө** | **279,878.30** | **299,920.00** | 20041.7 |
| Өр төлбөр | 1209 | 2,714.90 | 1505.9 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 278,669.20 | 297,205.10 | 18535.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **279,878.30** | **299,920.00** | 20,041.70 |

Бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст үлдэгдэлгүй. Оны эхний 3.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой тооцоо нийлж баталгаажуулаагүй авлага байна.

Бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оны үлдэгдлээс 0.8 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Тайлант онд 93.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, хандиваар 1.8 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 94.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Хүнсний материалын үлдэгдэл тооллогоор 5.7 төгрөг боловч санхүүгийн тайланд 10.2 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө нь мөн 19.2 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 5.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 19.1 сая төгрөг үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгөнд 5.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 18.5 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 18.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогчоор ажиллаж байсан хүмүүс тайлант онд хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байгаа тул 2022 оны төсвийн төслийн талаар мэдээлэл олж авах боломжгүй байсан болно.

Цэцэрлэгийн 2022 оны төсвийг 500.8 сая төгрөгөөр баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол 2 удаа хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 437.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 63.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 437.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 63.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 0.44 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 510.8 сая төгрөг буюу 99.9 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийг дэмжих | 1110 | 1110 | 0 | 100% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 57073.5 | 57073.5 | 0 | 100% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 13500.1 | 13500.1 | 0 | 100% |
| 4 | Боловсролын байгууллагын багш | 218.9 | 218.9 | 0 | 100% |
| 5 | Боловсрол стандарт сургалт | 384586.2 | 384145.9 | 440.3 | 100% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 44338.3 | 44338.3 | 0 | 100% |
| 7 | Нийтлэг үйлчилгээ | 443.5 | 443.5 | 0 | 100% |
| | **Дүн** | **501270.5** | **500830.2** | 440.3 | **99.98%** |

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр И.Айгүлээс 9.9 сая төгрөгийг цэцэрлэгийн дансанд оруулсан байна. Үүнээс 6.9 сая төгрөгийг хүн амын орлогын албан татварт, 2.4 сая төгрөгийг хоол хүнсний материал авахад, 0.3 сая төгрөгийг шатахууны зардалд, 0.2 сая төгрөгийг цахилгааны зардалд төсвийн зарцуулалтын эрх авалгүйгээр нэр данс зөрүүтэй ангиллаар зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчаас 0.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үүнээс багш нарын үнэлгээний бичиг хэргийн материалд 0.1 сая төгрөг зарцуулсан.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор К.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 433.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг нийт дүнгээр 0 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 8.3 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөн. Хэрэгжилтийг шалгаж үзэхэд хүнсний материал үлдэгдлийн зөрүү, санхүүгийн тайланд олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 8333.0 | | | 0% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **8333.0** | | | **0%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Дараагийн аудитаар нярвын бараа материалын тооцоо, тооллого хийсэн байдалд нарийвчлан анхаарч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 34.2 сая төгрөгийн зөрчил илэрч 25.2 сая төгрөгийн албан шаардлага, 9.0 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

### 5.1 Төлбөрийн акт

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 25.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.Үүнд:

1.Цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн А/25 тоот тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг томилж, тооллого хийсэн боловч тооллогыг зохих журмаар хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, хүнсний бараа материалаас бусад бараа материалын тооллого хийгээгүй.

Хүнсний материалын үлдэгдэл тооллогоор 5731.0 мянган төгрөг, санхүүгийн тайлангаар 10247.0 мянган төгрөгөөр тайлагнасан бөгөөд аудитаар хийсэн тооцоогоор үлдэгдэл 4817.0 мянган төгрөг гарч байна. Үүнээс олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3452.6 мянган төгрөгийн авлагын тооцоог хасахад үлдэгдэл 1977.4 төгрөг зөрүүтэй байна.

2.Хүнсний зарлага нярвын тайлангийн анхан шатны баримтаар 70,615.8 мянган төгрөг боловч санхүүгийн тайлангаар 65,185.8 мянган төгрөгөөр тусгаж 5,430.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

3.Цэцэрлэг нь 2022 оны 21344 хүүхэд өдрөөр нийтдээ 70,615.8 мянган төгрөгийн хүнсний материал буюу хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 3054 төгрөг зарцуулж, нэг өдрийн хоолны зардлын нормтой харьцуулахад өдөрт 833 төгрөгөөр, жилийн дүнгээр 17,789.4 мянган төгрөгөөр нормативыг хэтрүүлэн зарцуулсан байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой *асуудал***

*1.1.Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2.Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж тушаалаар батлуулан, санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах;

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1.Илрүүлэлт:*

3. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 9.0 сая төгрөгийн 6 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 79.4 хувьтай байна.

*2.2.Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах, гарсан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулсан | Залруулаагүй | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хүнсний материалын үлдэгдэл болон зарцуулалтын тайлагналын зөрүү | 1 | 7407.4 | | | 1 | 7407.4 | | | | | | |
| Хүүхдийн нэг өдрийн хоолны нормативыг хэтрүүлэн зарцуулсан | 1 | 17789.4 | | | 1 | 17789.4 | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| **Дүн** | **3** | **25196.4** | | | **2** | **25196.4** | **1** | **0.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 6 шийдвэрийг мэдээлээгүй | 1 | 9000.0 | | | | | 1 | 9000.0 |
| **Дүн** | 1 | 9000.0 | | | | | 1 | 9000.0 |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 0 | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **9000.0** | | | | | **1** | **9000.0** |